



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/119

Номгон

Коронавирусын халдвараас урьдчилан
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “б”, 29.1.6-ын “в”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/02, А/55, А/72 дугаар захирамж, Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, аймгийн Онцгой комиссын 2021 оны 11 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод голомтлон тархсан коронавирусын халдварт өвчин тус аймагт зөөвөрлөгдөн орж ирэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 08:00 цагаас 02 дугаар сарын 23-ны өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд зөвшөөрөгдсөн салбарын үйл ажиллагаанаас бусад салбарын үйл ажиллагаа болон зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, аймгийн хэмжээнд архи согтууруулах ундааны зүйлс худалдан борлуулахыг түр хориглосугай.

2. Дээрх хугацаанд эрчим хүчээр хангах, хүнсний үйлдвэрлэл, түгээлт, тээвэрлэлт, газрын тосны бүтээгдэхүүн, түгээлт, тээвэрлэлт, малын өвс, тэжээл, түгээлт, тээвэрлэлт, улсын онц чухал объект, стратегийн ач холбогдол бүхий объектын хамгаалалт, хот суурин газрын усан хангамж болон ариутгал халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн байгууллага, эм, эмнэлгийн хэрэгслийн ханган нийлэх үйл ажиллагаа, банк, санхүүгийн салбар (10:00-13:00 цагийн хооронд), хэвлэл мэдээлэл, харилцаа, холбоо, шуудан, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд, шүүх, прокурор, өмгөөлөл, наториатын үйл ажиллагаа (халдвар хамгааллын дэглэмийн дагуу), төрийн захиргааны байгууллагууд (тусгай зохицуулалтын дагуу), хүүхэд хамгаалал, асран хамгаалах халамжийн байгууллагууд, буяны ном, оршуулгын үйл ажиллагааг тусгай горимын дагуу явуулахыг тус тус зөвшөөрсүгэй.

1210295

2.

3.Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж байгаатай холбогдуулан дараах үйл ажиллагааг зохион байгуулахыг үүрэг болгосугай. Үүнд:

3.1. Цагаан сарын баярыг нийтээр тэмдэглэхгүй байх шийдвэртэй холбогдуулан “Иргэд ба халдвар хамгаалал” нэгдсэн арга хэмжээний зохион байгуулалтыг өргөжүүлж, гэрийн ажиглалтыг нэмж, төрийн бүх шатны байгууллагуудыг хамруулан нэгдсэн хуваарийг гарган явган эргүүл хийж, зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж)-т,

3.2. Хөдөлгөөн хязгаарлах хяналтын постуудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, аймгийн хэмжээнд зөвшөөрөгдсөн салбараас бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хязгаарлалтын дэглэмийн үед тусгаарлах байрны болон гэрийн тусгаарлалтын дэглэм зөрчсөн, хориглосон хугацаанд архидан согтуурах, согтууруулах ундааны зүйлс худалдан борлуулсан, төрийн албан хаагчийн шаардлага биелүүлээгүй иргэдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-т,

3.3. Дээрх хугацаанд голомтын бүсээс ирсэн иргэдийг түргэвчилсэн болон PCR шинжилгээнд бүрэн хамруулж, тандан судлах ажлыг хөдөлгөөнт хэлбэрээр зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т,

3.4. Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабаас гаргасан нэгдсэн хөдөлгөөнт болон явган эргүүлийн хуваарийн дагуу ажилтан алба хаагч нараа дайчлан ажиллуулж, хариуцсан газар оронд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны төрөл хамаарахгүй аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, боловсрол, соёл урлагийн бүх шатны байгууллага болон банк, санхүүгийн байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт,

3.5. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан аймгийн болон сумдын Онцгой комиссын Шуурхай штабуудын үйл ажиллагааг өдөр тутамд нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга (дэд хурандаа Э.Батбаяр)-д,

3.6. Эрүүл мэндийн шалтгаанаар болон Онцгой комиссын хойшлуулшгүй ажлаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөн үйлдэх тохиолдолд аймаг дотроо сумдын Онцгой комиссын шуурхай штабын зөвшөөрлийн бичгээр, аймаг болон хот


3.

хооронд явах тохиолдолд сумаас аймгийн Онцгой комисст хандаж, зөвшөөрлийн бичиг авч, бусад аймгийн нутаг дэвсгэрээр иргэдийг хүндрэлгүй явуулах,

3.7. Хөрш зэргэлдээ аймгуудын хил залгаа сумдуудын албан бус болон орон нутгийн чанартай төв замууд, сум тойрсон хяналтын постыг нэмэлтээр гаргаж, гарах зардлыг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэх,

3.8. Гэрийн ажиглалтад байгаа иргэдийг хянах ажлыг аймгийн Онцгой комиссын даргын 2021 оны 03 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсгийг байгуулж, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, өдөр бүр 09:00 цаг болон 21:00 цагуудад мэдээг Тагнуулын хэлтсийн тусгай дугаар (70442158)-т хүргүүлэх, тусгаарлах байрыг нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлтгэн захирамжаар томилгоожуулан, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, тусгаарлах байрны үйл ажиллагаанд өндөр ач холбогдол өгч ажиллахыг тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН